“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

| МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Үзмэрийн нэр | Хувийн дугаар | Тоо ширхэг | Хэмжээ | УБМС-ийн дугаар RCH (прораммын) | Судлагдсан сурталчлагдсан байдал | Саналын үндэслэл | СӨҮТ-ийн санал |
| 1 | Марзан Шаравын хөрөг /монгол зураг | Ү.71-68-7 | 1 | Өргөн-75см өндөр-91см | 1125ҮТМ03327 | Л.Сономцэрэн, Л.Батчулуун "Монголын дүрслэх урлагийн товч түүх" 1989 он.<br>– Марзан шарав судлал.<br>-Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн үзэсгэлэнд дэлгэгдсэн. 2023 он | Ардын зураач А.Сэнгэцохио /1917-1986/. “Зураач Б.Шарав” хөрөг зургийн тухай.<br>Монгол улсын ардын зураач Адъяагийн Сэнгэцохио нь: зураач Балдуугийн Марзан Шаравын шавь нарын нэг гэгддэг.<br>Уг бүтээлдээ А.Сэнгэцохио багшийгаа бүтээл урлан буйгаар урлажээ.Зохиомжийн туслах дүр болох арын хэсэгт /зүүн гар талын арын хэсэгт/ “хар шар фиодал” зургийн тэгийг татаад,тэнгэрийг цагаан цэнхэр өнгөөр талласанаар зурсан /шланшат/ байдаг.<br>Хар шар фиодал зургийг Б.Шаравыг зурсан, зураагүй гэх яриа байдаг. Тэгвэл түүнийг Б.Шарав зураач зурж байхад нь түүний шавь зураач А.Сэнгэцохио дэргэд нь байсан ба /хожим өөрийн бүтээлдээ тусган үлдээж чаджээ/ дээрхи зургийг Шарав зурсныг баталсан түүхэн хөрөг зураг болж үлдсэн, гэх үндэслэлээр санал оруулж байна.<br><br>Марзан Шарав судлаач,Бурхан зураач Харчин овогт Чулуунбатын Хишигчулуун. А.Сэнгэцохио,1962онд зурсан. | Дэмжсэн<br><br>Зураггүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хайрцаг /мөнгөн/1000 зааны зурагтай сав. | Ү.62-1-20 | 1 | Өргөн: 9.1см, Өндөр: 9.4см, Жин: 285гр, Зузаан: 5см | 1125ҮТМ15816 | VIII Богд Жибзундамба хутагтын 150 жилийн ойн үзэсгэлэнд дэглэгдсэн ба үзэсгэлэнгийн брошур /2019/ зэрэгт тус тус нийтлэгдсэн. | 1956 онд төв музейн үнэт зүйлийн фондыг байгуулахад шаардагдах зүйлүүдийн жагсаалтанд орж, Хааны тусгай хадгаламжаас музейд ирсэн үндэслэлээр. | Түдгэлзсэн<br><br>Зураггүй |
| 3 | Заан /мөнгөн/ | Ү.56ш-1-139 | 1 | Жин:8940гр | 1125ҮТМ09381 | Тус мөнгөн заан нь:2011 оны Нийслэл хүрээ түр үзэсгэлэн,2015 оны Монгол улс /1911-1919/, Монголын Үндэсний Музейн шилдэг үзмэрийн дээжис каталоги /2018/, VIII Богд Жибзундамба хутагтын 150 жилийн ойн үзэсгэлэнд дэглэгдсэн ба үзэсгэлэнгийн брошур /2019/ зэрэгт тус тус нийтлэгдсэн. | Богд Жибзундамба хутагтын цуглуулгад сүншиглэгдэн байж байгаад 1956 онд төв музейн үнэт зүйлийн фондыг байгуулахад шаардагдах зүйлүүдийн жагсаалтанд орж, Хааны тусгай хадгаламжаас музейд ирсэн үндэслэлээр. | Түдгэлзсэн<br><br>Зураггүй |
| 4 | Цуух хуур | Ү.93х-2-2 | 1 | Урт 81 см<br>Өргөн 15,5 см | 1125ҮТМ09381 | | Өдгөө энэ төрлийн хөгжмийн зэмсэг ихэд ховордсон | Түдгэлзсэн<br><br>Зураггүй |
| 5 | Пойлоос домбо | Ү.66х-56-2 | 1 хос | Өндөр 38 см, Дм 15 см | 1125ҮТМ01382 | *Богд хааны цайны домбо хийгээд хатны ташуур.* Монгол улс (1911-1921)каталог. Улаанбаатар, 2015.<br><br>Монголчуудын уламжлалт цагаан сар 2023 он | Монголын сүүлчийн эзэн хаан, 8-р Богд Жибзундамба хутагт хэрэглэж байсан. | Түдгэлзсэн<br><br>Зураггүй |
| 6 | Гутал | Ү.79х-17-2 | 1 хос | Урт: 21см, Өргөн: 8см, Өндөр: 32см | 1125ҮТМ14526 | *5-р Богдын гутал.* Музейн мэдээлэл. №06. Улаанбаатар, 2012. | Монголын шашны тэргүүн 5-р Богд хэрэглэж байсан. | Түдгэлзсэн<br><br>Зураггүй |
| 7 | Маршалын хувцас | Ү.62-8-245 | 1иж | | 1125ҮТМ05067 | Монгол улс 1921-2021 шилдэг үзмэрийн дээжс каталоги 2022 он | Маршал Х.Чойбалсан | Түдгэлзсэн<br><br>Зураггүй<br>Хэмжээ, жин дутуу |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | National museum of Mongolia каталоги 2009 он<br>“Бүгд найрамдах Монгол ард улсын маршал Хорлоогийн Чойбалсан 125 жил” 2020он | | |
| 8 | Булганы хүн чулуу | Y.2005-11-8 | 1 | | 1125YTM09602 | Эрдэнэбаатар Д., Ковалев А.А. Монгол Алтайн бүс нутгийн археологийн соѐлууд // Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. 2007. Vol. 3. №1(287). Т. 35–50. | Монгол орны хамгийн эртний хүн чулуун хөшөө бөгөөд хэмцэгийн үед холбогдоно. | Түдгэлзсэн<br><br>Зураггүй, Хэмжээ, жин дутуу |
| 9 | Маршалын од | 62-8-290 | 1 | Өргөн: 6.2см, Өндөр: 7.9см, Жин: 95гр, Диаметр: 6см | 1125YTM08393 | Монгол улс 1921-2021 шилдэг үзмэрийн дээж каталоги 2022 он<br>National museum of Mongolia каталоги 2009 он<br>“Бүгд найрамдах Монгол ард улсын маршал Хорлоогийн Чойбалсан 125 жил” 2020он | ЗХУ-ын монетны үйлдвэрт хийсэн. Маршал Х.Чойбалсанд олгосон маршалын од тэмдэг. | Дэмжсэн<br><br>Зураггүй |
| 10 | Мөнгөн үхэр | 71-134-63 | 1 | Өргөн: 16см, Өндөр: 12.5см, Жин: 640гр | 1125YTM19038 | Монгол улс 1921-2021 шилдэг үзмэрийн дээж каталоги 2022 он<br><br>Зууны бүтээн байгуулалт нэгдэлжих хөдөлгөөн каталоги 2022 он | МАХН-ын төв хороо, БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1944 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 1000, 5000, 10000 хүртэл мал өсгөсөн малчдад Улсын сайн малчин цол олгох тухай тогтоол гаргажээ. Тогтоол ёсоор Улсын алдарт сайн малчин цол, хүндэт үнэмлэх, сүргийн олонхийг эзлэж байсан хээлтүүлэгч малын мөнгөн дүрс, мөнгөн бүслүүртэй мөнгөн үсэг бүхий хувин, төрийн сүлдтэй мөнгөн самбар, эрээн майхан,өвсний морин хадуур , | Дэмжээгүй |
| 11 | Мөнгөн ямаа | 77-8-2 | 1 | Хэмжээ: 7 лан 5 цэн | 1125YTM06946 | | | Дэмжээгүй |
| 12 | Мөнгөн тэмээ | 71-134-62 | 1 | Урт: 19см, Өргөн: 9см, Өндөр: 17.5см, Жин: 815гр | 1125YTM10134 | | | Дэмжээгүй |
| 13 | Мөнгөн хонь | 77-8-1 | 1 | Өргөн: 12.5см, Өндөр: 13см, | 1125YTM03399 | | | Дэмжээгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Жин: 400гр, Хэмжээ: 10 лан | | | малын хашаа зэргийн улсаас дурсгаж эхэлсэн байна.<br>Анх 1945 онд улсын алдарт сайн малчин цолыг 97 малчинд олгоход Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын ард Чойдоржын сүргийн дотрох олон мал нь тэмээ учир буурын дүрс, Говь-Алтай аймгийн Цогт сумын Пэрэнлэй сүргийн олонх нь ямаа учир уханы дүрс, бусад 95-н айлд хуцны дүрс хүлээн авсан байна. шагналыг Д.Гүнд, Г.Лхавгасүрэн зэрэг үйлдвэр хоршоолын нэртэй уран дарханчууд урлаж байжээ. | |
| 14 | Мөнгөн морь | 71-134-64 | 1 | Урт: 19см, Өргөн: 9см, Өндөр: 17.5см, Жин: 815гр | 1125YTM10134 | | | Дэмжээгүй |
| 15 | Мөнгөн самбар | 81-2-14 | 1 | Өргөн: 29см, Өндөр: 21см, Жин: 1505гр | 1125YTM09095 | | | Дэмжээгүй |
| 16 | Эрдэнийн очир одонгийн 3-р зэргийн 4-р одон | Y.62-1-1 | 1 | Өргөн: 5см, Өндөр: 11см, Жин: 40гр | 1125YTM14894 | “Музей судлал” эрдэм шинжилгээний цуврал боть Tomus XX-I, F1-25 2019 он.<br>National museum of Mongolia каталоги 2009 он | ЭРДЭНИЙН ОЧИР ОДОН<br><br>1911 онд манай монголын ард түмэн Манжийн түрэмгийлэгчдийн дарлалаас ангижирч тусгаар тогтнож автономит засгийг байгуулсны дараа гадаадын хүмүүсийг шагнахад зориулж 1913 онд “Эрдэнийн очир” гэдэг одонгийн дүрэм маягийг зохион гаргажээ.<br>Уг одонг Хаант оросын нийслэл Петербург хотын Бокын түүсэнд үйлдвэрлэсэн одон бол:<br>- Тэргүүн<br>- Дэд<br>- Гутагаар гэж гурван зэргээр ялгажээ.<br>Тэргүүн зэргийн Эрдэнийн Очир одон нь дотроо гурван зэргээр ялгана.<br>1/ Чингис хааны одон гэж нэрлээд гадаад улсын хаадад шагнах. | Дэмжсэн<br><br>Зураггүй |
| 17 | Эрдэнийн очир одонгийн 3-р зэргийн 5-р одон | Y.62-1-2 | 1 | Өргөн: 5см, Өндөр: 11см, Жин: 35гр | 1125YTM03510 | “Музей судлал” эрдэм шинжилгээний цуврал боть Tomus XX-I, F1-25 2019 он.<br>National museum of Mongolia каталоги 2009 он | | Дэмжсэн<br><br>Зураггүй |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2/ Автай сайн хааны одон гэж нэрлээд гадаад улсын хаадын тайж /агь/ вангуудыг шагнах.<br>3/ Өндөр гэгээний одон гэж Шижир алт, төв дунд ба оройд сувд шигтгэнэ. Оосор нь шар лент байна.<br>Дэд зэргийн одон дотроо дөрвөн зэрэгтэй<br>1/ Вангийн зэргээр<br>2/ Бэйлийн зэргээр<br>3/ Бэйсийн зэргээр<br>4/ Гүнгийн зэргээр байна.<br>Алт шармал мөнгө, төв дунд улаан эрдэнийн чулуу оройд цулгай шүр, биндэръяа номин чулуу шигтгэсэн байна. Оосор нь улаан лент<br>Гутгаар зэргийн одон таван зэрэг<br>1/ Тэргүүн зэрэгт түшмэлийн зэргээр<br>2/ Дээд –“—<br>3/ Гутгаар --“—<br>4/ Дөтөгөөр --“—<br>5/ Тавдугаар –“—алт шармал мөнгө төв дунд цулгуй ба сийлбэртэй шүр биндэръяа номин цүүшлэн шигтгэнэ. Оосор нь хөх лент<br>Энэ одонгийн дотор 9 эрдэнэ гэдгийг оруулахыг чухал болгосон 1/ Алт, 2/ Мөнгө, 3/ Шүр, 4/ Сувд, 5/ Оюу, 6/ Номин, 7/ Дун, 8/ Зэс, 9/ Ган эдгээрийг 9 эрдэнэ гэж нэрлэдэг.<br>Манай монгол улс Манж дайчин улсын дарлалаас салж тусгаар тогтносон улс болсны бэлэг тэмдгийн нэг болох гавъяаны одон тэмдгийг зохиохдоо энэхүү | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрдэнийн очир гэдэг солбимол очирыг хэрэглэсэн байна.<br>Улсын цэргийн дэд дунд тушаалтны тэмдэгт хэрэглэж байжээ. | |
| **НИЙТ 17 ДЭСИЙН 18** | | | | | | | | |